



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 05 сарын 07 өдөр

Дугаар А/10

Улаанбаатар хот

Үндэсний онцлог бүхий жуулчны мэдээлэл сурталчилгааны төвийн ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалт 50 дугаар зүйлийн 50.1.1. дэх заалт, 50.4. дахь хэсэг, нийслэлийн Засаг даргын 2024 оны А/476 дугаар захирамж, 2022 оны 155 дугаар захирамжаар батлагдсан газрын дүрмийн 7.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний онцлог бүхий жуулчны мэдээлэл сурталчилгааны төвийг Жанжин Д.Сүхбаатарын талбайд байгуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг 1 дүгээр, төсөл арга хэмжээний жагсаалтыг 2 дугаар хавсралт ёсоор баталсугай.

2. Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо (О.Нямбат)-нд үүрэг болгосугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2024 оны... 05 дугаар... сарын
...07-на... өдрийн... А10 дугаар... тушаалын
нэгдүгээр хавсралт

ҮНДЭСНИЙ ОНЦЛОГ БҮХИЙ ЖУУЛЧНЫ МЭДЭЭЛЭЛ
СУРТАЛЧИЛГААНЫ ТӨВИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭГЧ СОНГОН
ШАЛГАРУУЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Үнэлгээний хорооны дарга:

О.Нямбат
Бодлогын баримт бичгийн тайлан, сургалт
хариуцсан ахлах мэргэжилтэн

Гишүүд:

М.Оргил
Иргэн (Хан-Уул дүүргийн 2 дугаар хороо)

Үнэлгээний хорооны
Нарийн бичиг:

Б.Энхцэцэг
Аяллын бүтээгдэхүүний хөгжүүлэлт
хариуцсан мэргэжилтэн

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2024 оны 05-р сарын
01 өдрийн 1170 дугаар
тушаалын 2 дугаар хэвсрэлт



ҮНДЭСНИЙ ОНЦЛОГ БҮХИЙ ЖУУЛЧНЫ МЭДЭЭЛЭЛ
СУРТАЛЧИЛГААНЫ ТӨВИЙГ БАЙГУУЛАХ ЖАГСААЛТ, ТӨСӨВ

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2024 онд санхүүжлэх дүн
		Эхлэх	Дуусах		
1	“Үндэсний онцлог бүхий жуулчны мэдээлэл сурталчилгааны төв”-ийг Жанжин Д.Сүхбаатарын талбайд гэр хэлбэрийн зөөврийн сууц байгуулах ажлын зардал	2024	2024	100,000,000	100,000,000
ДҮН				100,000,000	100,000,000